| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 240,000.00 | 2,860,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 29,560,866.00 | 43,944,399.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **00.00** | **00.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

# 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

## 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Цагдаагийн газар нь Цагдаагийн албаны тухай, Зөрчлийн тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Эрүүгийн хуулийн дагуу хуулийг дээдлэн, хүний эрхийг хамгаалж, амар тайван амьдралын баталгааг хангах, хүний эрхийг дээдлэн үйл ажиллагаандаа иргэдийн оролцоо, дэвшилтэт технологийн ашиглалтыг нэмэгдүүлэх, алба хаагчдын эрүүл мэнд, хууль ёсны эрх ашгийг хамгаалж хүний нөөцийн тогтвортой байдлыг бүрдүүлж ажиллах, гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэгтэй ХЗДХЯ-ны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь 2023 онд удирдлагын тасаг, захиргаа, удирдлагын тасаг, шуурхай албаны тасаг, эрүүгийн цагдаагийн тасаг, мөрдөн байцаах тасаг, зөрчлийн хэрэг бүртгэх тасаг, замын цагдаагийн тасаг, Жаргалант, Богд, Бууцагаан сум дахь сум дундын тасаг гэсэн 10 тасагтай 160 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж, тайлант онд үйл ажиллагааны зардалд улсын төсвийн санхүүжилтээр 4,853,532.8 мянган төгрөг батлагдсан байна.

Баянхонгор аймгийн Цагдаагийн газар нь “Монгол цагдааг өв тэгш хөгжүүлэн мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, албаны чадамжийг дээшлүүлнэ”, “Цагдаагийн албаны бодлого, төлөвлөлт, зохицуулалтын чанарыг дээшлүүлж, байгууллагын чадавхыг дээшлүүлнэ”, “үйл ажиллагааны мэргэшсэн байдлыг хангаж, үр дүнг нэмэгдүүлнэ”, Өндөр мэдээллийн технологийг нэвтрүүлэх,


005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

цагдаагийн инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх замаар үйл ажиллагааны баталгаатай, найдвартай байдлыг хангах", "Иргэдийн оролцоо, бүх талын хамтын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр" гэсэн 5 зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Дарга Б.Мөнхбаяр (2023.01.01-2023.12.31), 2 дугаар гарын үсгийг ахлах нягтлан бодогч О.Сувд-Эрдэнэ (2023.01.01-2023.06.15), Б.Пүрэвсүрэн (2023.06.15-2023.08.23), Б.Нандинцэцэг (2023.08.23-2023.12.31) нар зурж, тооцооны нягтлан бодогчоор Б.Даваацэрэн, М.Бодьцэцэг, нярваар Баасансүрэн, Б.Пүрэвсүрэн, Н.Нагерренчин нар ажиллажээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль шинээр батлагдаж мөрдөж эхэлсэн.
- Цагдаагийн албаны тухай, Зөрчлийн тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Төсвийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг мөрдөж ажилласан.
- Засгийн газрын 2023 оны "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дүгээр тогтоол.
- Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоол.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүргийг Цагдаагийн ерөнхий газрын дотоод хяналт-аюулгүй байдлын газар хэрэгжүүлдэг ба 2017-2022 оны баримтад хяналт шалгалт хийж 29,350.4 мянган төгрөгийн зөрчил илэрч, 562,469.6 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Цагдаагийн газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Тус байгууллагын үйл ажиллагаандаа мөрддөг Хууль зүйн яамны салбарын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 4,010,939.3 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 203,732.7 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* (мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 19,716.3 | 51,882.3 | 32,166.0 |
| Авлага | 14,691.6 | - | (14,691.6) |
| Бараа материал | 219,452.8 | 245,563.3 | 26,110.5 |
| Үндсэн хөрөнгө | 5,286,885.5 | 5,333,707.8 | 46,822.4 |
| Хуримтлагдсан элэгдэл | (1,326,074.2) | (1,622,633.8) | (296,559.6) |
| **Нийт хөрөнгө** | **4,214,672.0** | **4,008,519.7** | **(206,152.3)** |
| Богино хугацаат өр төлбөр | 129.2 | 1,551.0 | 1,421.8 |
| Засгийн газрын хувь оролцоо (Эздийн өмч) | 4,214,542.8 | 4,006,968.7 | (207,574.1) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **4,214,672.0** | **4,008,519.7** | **(206,152.3)** |

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл 51,882.3 мянган төгрөг байгаа нь ахмадын сангийн хөрөнгийг зарцуулаагүй үлдэгдэлтэй байгаатай холбоотой байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 14,691.6 мянган төгрөг бөгөөд малчнаас авах малын авлага малаар барагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 245,563.3 мянган төгрөг болж өмнөх оноос 26,110.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 163,069.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 14,691.6 мянган төгрөгийн авлага малаар барагдсан, малын нас дэвшилтийн орлогоор 12,378.9 мянга, үндсэн хөрөнгөөс шилжиж ирсэн 25,173.5 мянга, 2,395.0 мянга, бусад байгууллагаас 60,799.8 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч, бусад байдлаар 27,554.9 мянган төгрөгийг бараа материалыг шилжүүлж, 5,527.4 мянган төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассан, үйл ажиллагаандаа 219,314.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,333,707.8 мянган төгрөг болж 46,822.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 4,608.5 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/50 дугаар тушаалаар бараа материалын данснаас 14,460.5 мянга, ЦЕГ-аас 15,148.4 мянга,



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

ХЗДХЯ-аас 29,988.5 мянга, аймгийн ИТХ-аас 7,790.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авч, газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/50 дугаар тушаалаар 25,173.5 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалд шилжүүлж, 17,305.5 мянган төгрөгийн хөрөнгийг данс хооронд шилжүүлсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 207,574.1 мянган төгрөгөөр буурч 4,006,968.7 мянган төгрөг болсон байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,086,219.7 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 71,918.0 нийт зарлагыг 4,158,137.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант хугацаанд 695,395.1 мянган төгрөгөөр бууруулж улсын төсвөөс 4,791,179.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 62,352.9 мянган төгрөг, нийт 4,853,532.8 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 4,791,179.9 мянган санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,791,179.9 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 125,066.7 мянган төгрөг, нийт 4,916,246.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 61,484.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,854,398.2 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 61,484.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

(мянган төгрөгөөр)

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| | **Улсын төсөв** | | | | |
| 1 | 70704 Цагдаа | 4,637,700.1 | 4,577,640.1 | 60,982.8 | 99.95% |
| 1.1 | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 4,296,409.8 | 4,237,427.2 | 58,982.4 | 98.63% |
| 1.2 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж | 334,690.3 | 333,613.3 | 1,077.0 | 99.68% |
| 1.3 | 82315 Байцаан шийтгэх ажиллагаа | 6,600.0 | 6,599.6 | 0.4 | 99.99% |
| 2 | 70711 Шүүгч болон гэр, хохирогчийн | 153,479.8 | 151,691.3 | 1,788.5 | 98.83% |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2.1 | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 153,479.8 | 151,691.3 | 1,788.5 | 98.83% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Өөрийн үндсэн үй ажиллагааны орлогыг давуулан биелүүлсэнтэй холбоотойгоор хэмнэлт бий болсон байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дараах орлого төвлөрсөн байна. (мянган төгрөг)

| № | Санхүүжилт олгосон байгууллага | Орлогын төрөл | Санхүүжилтийн дүн |
|---|---|---|---|
| 1 | ЦЕГ-ын Санхүү ар талын газар | ИТХ-ын нөхөн болон дахин сонгуулийн зардал | 2,860.0 |
| 2 | ЦЕГ-ын Санхүү ар талын газар | Тушаалын дагуу давсан орлого | 5,775.8 |
| 3 | Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | ГХУСЗЗ-ийн зардал | 1,000.0 |
| 4 | Баянхонгор аймгийн ЗДТГ | Баянхонгор аймгийн Засаг даргын 2023 оны А/178 дугаар захирамж (Дата симний эрх) | 3,060.0 |
| 5 | | Баянхонгор аймгийн Засаг даргын 2023 оны А/265 дугаар захирамж | 2,000.0 |
| 6 | Бусад орлого | Ноолуурын орлого | 2,800.0 |
| 7 | | Түрээсийн орлого | 4,874.0 |
| 8 | | Галт зэвсгийн сургалтын төлбөрийн орлого | 19,810.0 |
| 9 | | Авто машины засварын мөнгө | 5,091.6 |
| 10 | | Албан хаагчдаар төлүүлсэн шатахуун | 1,532.9 |
| | **Нийт дүн** | - | **48,804.3** |

Дээрх хөрөнгүүдийг зориулалтын дагуу зарцуулж үрийн мөнгөний орлого 6,301.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тээвэр шатахууныг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, бичиг хэрэг, урсгал засвар, хоол хүнсний зардлыг тендер шалгаруулалтын онцгой журмаар шалгаруулахаар төлөвлөсөн байна.

Шатахууны тендер шалгаруулалтад "Ник" ХХК шалгарч 116,429.1 мянган төгрөгийн үнийн санал ирүүлж хамгийн сайн үнэлэгдэж гэрээ байгуулсан байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Бичиг хэргийн материал нийлүүлэх гэрээг “Цогц мандах өглөө”, урсгал засварын гэрээг “Цэлмэг өглөө” ХХК-тай, хоол, хүнс нийлүүлэх гэрээг “Явуу хэлхээ” ХХК-тай тус тус байгуулсан байна.

Тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 158,250.9 мянга, гэрэл цахилгааны зардалд 30,085.2 мянга, цэвэр, бохир усны зардалд 15,928.9 мянган төгрөг батлагдаж “Зүүн шанд” ХХК-тай дулаанаар хангах гэрээ, "Баянхонгор-Эрчим хүч" ЦТХХК-тай цахилгаан, эрчим хүчээр хангах гэрээ, "Чандмань-Баянхонгор" ХК-тай цэвэр, бохир усаар хангах гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Цагдаагийн газар нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 31-1/5772 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсөв 4,769,900.0 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсөв 4,791,179.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 47,911.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 33,538.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд хуулийн хэрэгжилтийг шалгахад 2023 оны гэрэл цахилгааны зардлыг 10,156.8 мянга, тээвэр шатахууны зардлаас 4,357.2 мянган төгрөг хэмнэсэн зардал хооронд шилжүүлэн зарцуулсан байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2023 онд 159 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 150 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст 5 гэрээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 463,420.9 мянган төгрөгийн 30 гүйлгээ мэдээлэхээс 97,897.5 мянган төгрөгийн 8 гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгээгүй болно.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 10,437.2 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс 9,653.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж, 783.6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоосныг биелүүлж ажиллан биелэлтийг Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын даргын 2023 оны 06 дугаар 21-ний өдрийн 31-1/2999 дүгээр албан бичгээр ирүүлснийг биелэлтийг тооцож FAS системд оруулсан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 2 | 783.6 | 2 | 783.6 | 100 |
| Зөвлөмж | 2 | 9,653.5 | 2 | 9,653.5 | 100 |
| **Нийт дүн** | **4** | **10,437.2** | **4** | **10,437.2** | **100** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баянхонгор аймгийн Цагдаагийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн санхүүгийн тайлан нь зөрүүтэй, үндсэн хөрөнгө, бараа материалын ангиллыг буруу бичсэнийг аудитаар залруулсан бөгөөд цаашид данс бүртгэл хооронд шилжүүлэхдээ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан эсэхийг шалгах.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 127,958.2 мянган төгрөгийн 3 алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Санхүүгийн тайланд үндсэн үйл ажиллагааны орлогыг 726.0 мянга, ахмадын сангийн дансны орлогыг 520.0 мянган төгрөгөөр дутуу тусгасан.
2. Мэдээлэл хүлээн авагч жижүүрийн цагдаа Ц.Мөнх-Оргилд өгөх томилолтын 96.0 мянган төгрөгийг авлагаар тусгаагүй.
3. Үндсэн хөрөнгө, бараа материалын данс хооронд шилжүүлэхдээ ангилал зөрүүтэй бүртгэсэн, малыг нас дэвшүүлэн орлого авахдаа буруу дэвшүүлсэн, бусад байгууллагаас ирсэн хөрөнгийг буруу ангиллаар бүртгэсэн нийт 126,616.2 мянган төгрөгийн хөрөнгийн ангиллыг залруулсан.

Аудитаар нийт 3,757.9 мянган төгрөгийн 2 зөрчил[2] илэрснээс, 2,206.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 1,551.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 3,757.9 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 29,779.4 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1. Бараа материалын тайланд "Цогц мандах өглөө" ХХК-иас худалдан авсан 2,206.9 мянган төгрөгийн бараа материалыг орлого авалгүйгээр шууд зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ыг зөрчсөн байна.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

*Шийдвэрлэсэн нь*: Бараа материалын тайланд тусгалгүй зарцуулсан хөрөнгийг буруутай албан хаагчаар төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

**5.2 Албан шаардлага**

5.2.1. Тус байгууллага нь суутган тооцсон ХХОАТ-ын 726.9 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн 728.1 мянга, томилолтын 96.0 мянга нийт 1,551.0 мянган төгрөгийн өр төлбөртэй байхад цалингийн сангаас 41,183.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж данснаас 6,465.0 мянга нийт 47,648.6 мянган төгрөгийн ахмадын дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Өр төлбөрийг барагдуулж, цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг өгөв.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.


005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

# 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланд буруу бүртгэсэн | 1 | 1,246.0 | - | - | 1 | 1,246.0 | 1 | 1,246.0 | - | - |
| Санхүүгийн тайланд бүртгээгүй | 1 | 96.0 | 1 | 96.0 | - | - | 1 | 96.0 | - | - |
| Санхүүгийн тайланд буруу бүртгэсэн | 1 | 126,616.2 | - | - | 1 | 126,616.2 | 1 | 126,616.2 | - | - |
| Дүн | **3** | **127,958.2** | **1** | **96.0** | **2** | **126,712.2** | **3** | **127,958.2** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бараа материалын тайланд “Цогц мандах өглөө” ХХК-иас худалдан авсан 2,206.9 мянган төгрөгийн бараа материалыг орлого авалгүйгээр шууд зардлаар тайлагнасан байна. | 1 | 2,206.9 | 1 | 2,206.9 | - | - | - | - |
| Тус байгууллага нь суутгасан тооцсон ХХОАТ-ын 726.9 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн 728.1 мянга, томилолтын 96.0 мянга нийт 1,551.0 мянган төгрөгийн өр төлбөртэй байхад цалингийн сангаас 41,183.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж данснаас 6,465.0 мянга нийт 47,648.6 мянган төгрөгийн ахмадын дансанд шилжүүлсэн байна.. | 1 | 1,551.0 | - | - | 1 | 1,551.0 | - | - |
| Дүн | **2** | **3,757.9** | **1** | **2,206.9** | **1** | **1,551.0** | **-** | **-** |

-----------оOо-----------



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 24/A0571121 Номгон
БНА-2024/14/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын тайланд “Цогц мандах өглөө” ХХК-иас худалдан авсан 2,206,900 төгрөгийн бараа материалыг орлого авалгүйгээр шууд зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг гэсэн заалыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

5050074

1. Бараа материалын тайланд орлого авалгүй зарцуулсан зардлын 2,206,900 (хоёр сая хоёр зуун зургаан есөн зуу) төгрөгийг төсвийн захирагч, нягтлан бодогч нараар төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх[1]

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын дарга Б.Мөнхбаяр, нягтлан бодогч М.Бодьцэцэг нарт даалгав[2].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[3]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Н.БАТЧИМЭГ

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[3] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 37/А0571121 БНА-2024/14/НА-СТА-ТШ3 Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь суутган тооцсон ХХОАТ-ын 726,891 төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн 728,113 төгрөг, томилолтын 96,000 төгрөг нийт 1,551,004 төгрөгийн өр төлбөр үүсгэж ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өр төлбөрийг барагдуулан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын дарга Б.Мөнхбаяр, нягтлан бодогч М.Бодьцэцэг нарт даалгав .

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН[1]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Н.БАТЧИМЭГ

6417143544

[1] Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

5040115